



ХАСБАНКНЫ КЛИРИНГИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Хувилбар 1.0

Хувилбар	1.0
Баталсан огноо	2024.9.12
Үнэлгээ хийх огноо	2026.9.12
Баталсан	Г. Цэвэгжав Гүйцэтгэх захирал
Боловсруулсан	Б. Оюунгэрэл Карт дижитал сувгийн албаны ахлах мэргэжилтэн, Картын бизнес, дижитал банкны газар
Хянасан	У. Замбага Газрын захирал Картын бизнес, дижитал банкны газар
Холбогдох эрх зүйн баримт бичгүүд	- Картын төлбөр тооцоо гүйцэтгэх үйл ажиллагааны журам - Төлбөрийн картын маргаантай гүйлгээг шийдвэрлэх журам
Дагаж мөрдөх	Банкны хэмжээнд
Тайлбар	
Нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, хүчингүй болгох	Нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, шинэчлэх, хүчингүй болгох асуудлыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
Дугаар	

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү дүрмээр ХасБанкны /цаашид “Банк” гэх/ клирингийн төвийн системд оролцогч хооронд гүйлгээ дамжуулах, төлбөр тооцоог зохион байгуулах, төлбөр тооцооны үр дүнг тооцоолох, хаалтын гүйлгээ хийхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Банкны клирингийн төвийн үйл ажиллагаа нь Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Банкны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Төлбөрийн системийн журам, Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.
- 1.3. Энэхүү дүрэмд болон холбогдох баримт бичгүүдэд хэрэглэсэн нэр томъёог Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Төлбөрийн системийн журам болон энэхүү дүрмийн 2 дугаар бүлэгт тодорхойлсон утгаар ойлгоно.

ХОЁР. НЭР ТОМЬЁО

- 2.1. Дүрэмд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно.
 - 2.1.1. “Клирингийн төв” гэж Монгол Улсын холбогдох хууль, дүрмийн дагуу Монголбанкнаас олгосон зөвшөөрлийн хүрээнд клирингийн системийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ХасБанкны клирингийн төвийг;
 - 2.1.2. “Гишүүн банк” гэж Клирингийн төвтэй Төлбөрийн картын төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ байгуулсан банкийг;
 - 2.1.3. “Эквайрингийн сүлжээ” гэж аливаа банкны процессингийн сүлжээ, системээс бүрдэл болсон картын цогц үйлчилгээний тогтолцоог;
 - 2.1.4. “Эквайрингийн сүлжээнд үйлчлүүлэх” гэж аль нэг банкны карт эзэмшигч өөр нэг банкны эквайрингийн сүлжээнд хийж буй санхүүгийн болон санхүүгийн бус гүйлгээг;
 - 2.1.5. “Оролцогч” гэж клирингийн системээр төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх шууд болон шууд бусаар төлбөр илгээх, хүлээн авах эрхтэй этгээдийг;
 - 2.1.6. “Шууд оролцогч” гэж харилцагчийн болон өөрийн, гэрээний үндсэн дээр шууд бус оролцогчийн төлбөр тооцоог хариуцан гүйцэтгэж байгаа оролцогчийг;
 - 2.1.7. “Шууд бус оролцогч” гэж төлбөр тооцоог гэрээний үндсэн дээр шууд оролцогчоор дамжуулан гүйцэтгэж байгаа оролцогчийг;
 - 2.1.8. “Үр дүнгийн тооцоолол” гэж хоёр ба түүнээс дээш оролцогчийн харилцан хүлээсэн төлбөрийн үүргийн цэвэр дүн болох үр дүнгийн тооцооллын хаалтын дүнг тодорхойлох үйл ажиллагааг;
 - 2.1.9. “Үр дүнгийн тооцооллын хаалтын дүн” гэж төлбөр тооцооны дүрмийн дагуу оролцогч хоорондын өглөг, авлагын дүнг цэвэршүүлж, нэг цэвэр авлага, эсхүл өглөг болгох үйл ажиллагааны үр дүнд бий болосон төлбөр тооцооны дүнг;
 - 2.1.10. “Үр дүнгийн төлбөр тооцоо” гэж тухайн өдөр оролцогч хооронд хийгдсэн шилжүүлгийн үр дүнгийн тооцооллыг нэг ба түүнээс дээш удаа тогтоосон хугацаанд холбогдох дансанд тусгах ажиллагааг;
 - 2.1.11. “Картаар үйлчлэгч байгууллага” гэж бараа, ажил үйлчилгээний төлбөрийг карт болон цахим мэдээ үүсгэгчийн тусламжтайгаар банкна дахь харилцах дансандаа хүлээн авах хэрэглэгчийг;

ГУРАВ. КЛИРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 3.1. Клирингийн төв нь шууд болон шууд бус оролцогч хоорондын картын гүйлгээг дамжуулах, үр дүнгийн тооцоолол хийх үйл ажиллагааг эрхэлнэ.
- 3.2. Клирингийн төвөөр дамжих гүйлгээ тус бүрийн мөнгөн дүнгийн дээд хэмжээ нь Монголбанкны тогтоосон бага дүнтэй төлбөрийн дүнгийн дээд хязгаараас хэтрэхгүй байна.
- 3.3. Энэхүү дүрмийн 3.2-т заасан мөнгөн дүнгийн дээд хэмжээ нь төлбөрийн картаар хийсэн гүйлгээнд хамаарахгүй.
- 3.4. Банк нь Монголбанк болон эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох эрх зүйн актыг хангасан шууд болон шууд бус оролцогчтой Төлбөрийн картын төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ байгуулан хамтарч ажиллана.
- 3.5. Банк нь Оролцогч болон Монголбанктай үйл ажиллагааны туршилт хийж, дүгнэлт гаргуулсан байна.
- 3.6. Клирингийн төв нь гүйлгээг дараах байдлаар дамжуулна.
 - 3.6.1. Хэрэглэгчийн цахим мэдээ үүсгэгчид төлбөрийн картаар дамжуулан үүсгэсэн шилжүүлгийн цахим мэдээг карт хүлээн авагч нь Клирингийн төвд илгээнэ.
 - 3.6.2. Клирингийн төв нь цахим мэдээг карт гаргагчид дараах байдлаар дамжуулна.
 - 3.6.2.1. Оролцогч хоорондын гүйлгээний хувьд карт гаргагчид /Олон улсын төлбөрийн систем болон оролцогчийн төлбөрийн картын гүйлгээний зураглалын Схем 1/,
 - 3.6.2.2. Оролцогч Үндэсний цахим гүйлгээний төв /цаашид “ҮЦГТ” гэх/ хоорондын гүйлгээг ҮЦГТ-өөр дамжуулан карт гаргагчид /Олон улсын төлбөрийн систем болон оролцогчийн төлбөрийн картын гүйлгээний зураглалын Схем 2/,
 - 3.6.2.3. Оролцогч VISA хоорондын гүйлгээг VISA international олон улсын төлбөрийн системээр дамжуулан карт гаргагчид /Олон улсын төлбөрийн систем болон оролцогчийн төлбөрийн картын гүйлгээний зураглалын Схем 3/,
 - 3.6.2.4. Оролцогч UPI хоорондын гүйлгээг ҮЦГТ-өөр дамжуулан карт гаргагчид /Олон улсын төлбөрийн систем болон оролцогчийн төлбөрийн картын гүйлгээний зураглалын 4/.
 - 3.6.3. Карт гаргагч нь тухайн цахим мэдээг шалгаж баталгаажуулан Клирингийн төвд илгээнэ.
 - 3.6.4. Клирингийн төв нь тухайн цахим мэдээг карт хүлээн авагчид дамжуулна.
 - 3.6.5. Карт хүлээн авагч нь тухайн цахим мэдээг эцэслэнэ.
- 3.7. Оролцогчийн илгээсэн цахим мэдээний хариуг 25 секунд хүлээнэ. Клирингийн төв нь дамжуулсан цахим мэдээний хариуг 20 секунд хүлээнэ.
- 3.8. Үндсэн гүйлгээг “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-д зааснаар ойлгоно. Оролцогч нь Монголбанкны баталсан холбогдох дүрмийн дагуу үндсэн гүйлгээг өөрийн системд карт гаргагч нь заавал, карт хүлээн авагч нь өөрийн төхөөрөмж, үйл ажиллагаанаас хамаарч сонголтоор тус тус нэвтрүүлнэ.
- 3.9. Оролцогч нь нэмэлт гүйлгээг “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-д зааснаар ойлгоно. Оролцогч нь Монголбанкны баталсан холбогдох дүрэмд заасны дагуу нэмэлт гүйлгээг системд нэвтрүүлж, хүлээн авна.
- 3.10. Клирингийн төв нь олон улсын төлбөрийн системд хийгдэх картын үйл ажиллагааг олон улсын төлбөрийн картын хамтран ажиллах гэрээ, эсхүл байгуулсан холбогдох гэрээний дагуу өөрийн клирингийн системээр дамжуулан гүйцэтгэж болно.

- 3.11. Олон улсын төлбөрийн систем болон Оролцогч хоорондын төлбөрийн картын гүйлгээг Олон улсын төлбөрийн систем болон оролцогчийн төлбөрийн картын гүйлгээний зураглалд зааснаар дамжуулна.
- 3.12. Олон улсын төлбөрийн системд хийгдэх гүйлгээ нь тухайн системийн дүрмийн дагуу зохицуулагдана.

ДӨРӨВ. ҮР ДҮНГИЙН ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ, ҮР ДҮНГИЙН ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ БАРЬЦАА

- 4.1. Клирингийн төв нь Оролцогч хоорондын төлбөрийн картын гүйлгээг өөрийн системээр дамжуулан гүйцэтгэнэ.
- 4.2. Клирингийн төв Оролцогч хоорондын ҮЦГТ-өөр дамжсан төлбөрийн картын гүйлгээний үр дүнгийн тооцооллыг харилцан суутгах зарчмаар хийнэ.
- 4.3. Клирингийн төв нь үр дүнгийн тооцоолол хийж, Гүйлгээ боловсруулах, үр дүнгийн төлбөр тооцоо хийх аргачлалд заасны дагуу Монголбанкны “Банксүлжээ” системд дамжуулна.
- 4.4. Клирингийн төв нь олон улсын төлбөрийн системээр хийгдсэн гүйлгээг тухайн системийн үр дүнгийн тооцооллын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 4.5. Шууд бус оролцогч нь үр дүнгийн тооцоо хийх зорилгоор Клирингийн төвийн дансанд тодорхой дүнг барьцаа хэлбэрээр байршуулан бариулна. Барьцаатай холбоотой харилцааг барьцааны гэрээ байгуулан, тухайн гэрээгээр зохицуулна.
- 4.6. Оролцогч хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх зорилгоор Банксүлжээ дэх төлбөр тооцооны дансанд тусгаарласан эх үүсвэрийн нөөцийн хэмжээ, түүний өөрчлөлтийн талаар Клирингийн төв болон Банксүлжээ хооронд солилцох цахим мэдээг нөөц баталгаажуулах мэдээ гэнэ.
- 4.7. Оролцогч нь Клирингийн төвөөр дамжуулан өөрийн нөөцийн хэмжээг өдөрт 5 удаа дараах цагуудад баталгаажуулна. Үүнд: 10:00, 11:30, 14:30, 15:30, 16:30 цаг.
- 4.8. Оролцогч нь Банксүлжээ дэх өөрийн нөөцийн хэмжээг Клирингийн төвтэй байгуулсан гэрээний дагуу удирдана. клирингийн төв нь тухайн өдрийн төлбөрийн картын банк хоорондын гүйлгээний үр дүнгийн төлбөр тооцоог Банксүлжээ системээр гүйцэтгэнэ.
- 4.9. Оролцогч нь нөөцийн удирдлага гүйцэтгэхэд дараах үүрэгтэй.
- 4.9.1. Нөөцийг зөв зохистой удирдах,
- 4.9.2. Үр дүнгийн төлбөр тооцоо хийх, мөн шимтгэлийн дүнг тооцож нөөцийн хязгаарыг тодорхойлох,
- 4.9.3. Нөөц болгон царцаасан мөнгөн хөрөнгөөс зөвхөн тухайн оролцогчийн гүйлгээний үр дүнгийн төлбөр тооцоог хийх,
- 4.9.4. Оролцогч нь нөөцийн мэдээллийг баталгаат сувгаар Клирингийн төвөөс авч солилцох,
- 4.9.5. Банксүлжээ системд клирингийн системээр дамжих гүйлгээний нөөцийг ажлын өдөр эхлэхэд хангалттай мөнгөн дүнгээр, эсхүл тухай бүр нэмэгдүүлэх.
- 4.10. Оролцогч нь өөрийн нөөцийг удирдахад дараах зүйл хийхийг хориглоно.
- 4.10.1. Тухайн өдрийн гүйлгээний үр дүнгийн төлбөр тооцоо хийх хүртэл нөөцийг чөлөөлөх,
- 4.10.2. Бусдад шилжүүлэх, зориулалтыг өөрчлөх.

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 5.1. ХасБанкны клирингийн төвийн үйлчилгээний ерөнхий нөхцөлийг ХасБанкны Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
- 5.2. Клирингийн төвийн шимтгэл:
 - 5.2.1. Клирингийн төв нь амжилттай дамжуулсан төлбөрийн картын гүйлгээний шимтгэлийг ХасБанкны клирингийн төвийн үйлчилгээний ерөнхий нөхцөлд заасны дагуу суутгаж авна.
 - 5.2.2. Клирингийн төв нь буцаалтын болон амжилтгүй гүйлгээнээс шимтгэл авахгүй.
 - 5.2.3. Буцаалтын гүйлгээний шимтгэлийг буцааж буй гүйлгээний дүнгээс тооцож, залруулга хийнэ.
- 5.3. Шимтгэл хуваарилах зарчим:
 - 5.3.1. Дотоодын гүйлгээ дамжуулсан карт хүлээн авагч болон карт гаргагчид ногдох шимтгэлийг Монголбанкнаас баталсан Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөл болон бусад холбогдох дүрэмд заасны дагуу хуваарилах бөгөөд олон улсын гүйлгээ дамжуулсан карт хүлээн авагч банк болон карт гаргагч банканд ногдох шимтгэлийг ХасБанкны клирингийн төвийн үйлчилгээний ерөнхий нөхцөлд заасны дагуу хуваарилна.

ЗУРГАА. МАРГААНТАЙ ГҮЙЛГЭЭ ШИЙДВЭРЛЭХ ЗАРЧИМ

- 6.1. Оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг Банкны “Төлбөрийн картын маргаантай гүйлгээ шийдвэрлэх журам” болон “Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм”-ийн дагуу шийдвэрлэнэ.
- 6.2. Оролцогч талуудын хооронд үүссэн маргаантай холбоотой хүсэлт илгээх, хүлээн авах, маргаан илгээх, хүлээн авахдаа Клирингийн төвийн dispute@xacbank.mn цахим хаягийг ашиглана.
- 6.3. Оролцогч талууд дараах төрөл, шалтгаанаар маргаан үүсгэнэ.

№	Маргааны төрөл, шалтгаан	Төхөөрөмжийн төрөл		
		АТМ	ПОС	ПОБ
1	Илүү эсхүл дутуу дүнгээр олгосон	+		+
2	Хуурамч эсхүл Алдагдсан картаар хийгдсэн гүйлгээ	+	+	+
3	Илүү эсхүл дутуу дүнгээр хийгдсэн		+	
4	Гүйлгээгээ санахгүй байгаа	+	+	+
5	Бэлнээр эсхүл өөр төлбөрийн картаар хийгдсэн		+	
6	Баримт хэвлэгдээгүй		+	+
7	Гүйлгээ автоматаар буцаагдсан	+	+	+
8	Бэлэн мөнгө гараагүй	+		
9	Гүйлгээ санамсаргүй буцаагдсан		+	+
10	Карт эзэмшигчээс дутуу дүнгээр хасагдсан		+	+
11	Давхар гүйлгээ хийгдсэн		+	
12	Бусад	+	+	+

- 6.4. Оролцогчид энэхүү дүрмийн 6.3-т заасан төрөл, шалтгаанаар маргаан үүсгэхдээ доорх нотлох баримтуудыг хавсаргана.
 - 6.4.1. Гүйлгээ санамсаргүй буцаагдсан бол гүйлгээний гарын үсэгтэй баримт, КҮБ-ийн хүсэлт,
 - 6.4.2. Карт эзэмшигчээс дутуу дүнгээр хасалт хийгдсэн бол КҮБ эсхүл карт хүлээн авагч талаас ирүүлсэн хүсэлт,
 - 6.4.3. Бусад шаардлагатай гэж үзсэн баримтууд.

- 6.5. Орогцогч нь зөвхөн амжилттай хийгдсэн гүйлгээнд маргаан үүсгэнэ.
- 6.6. Оролцогч Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдсэн гүйлгээний хувьд ажлын 30 хоногийн дотор маргаан үүсгэх хүсэлтээ гаргана.
- 6.7. Олон улсын системд хийгдсэн гүйлгээний хувьд олон улсын төлбөрийн системийн маргаан шийдвэрлэх дүрмийн дагуу шийдвэрлэгдэнэ.
- 6.8. Оролцогч талууд нь харилцан үйлчилгээ үзүүлэх явцад оролцогч талуудын хооронд болон оролцогч талуудын харилцагчид, бусад хуулийн этгээдтэй холбоотой маргаантай гүйлгээ, сэжигтэй гүйлгээ, нэмэлт мэдээлэл тодруулах шаардлагатай гүйлгээ, луйварын гүйлгээ, луйварын гүйлгээ хийх оролдлого гарсан зэрэг нөхцөл байдал үүссэн бол талуудын холбогдох ажилтан хамтран асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж, оролцогч талуудын картын үйлчилгээний нэр хүнд, чанарыг хамгаалах ба цаашид учирч болзошгүй эрсдэл, хохирол, алдагдал, зардал, үл ойлголцох байдлаас сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авна.

ДОЛОО. ШИНЭЭР ОРОЛЦОГЧ БҮРТГЭХ, ЦУЦЛАХ

- 7.1. Оролцогчид тавих ерөнхий шаардлага:
 - 7.1.1. Оролцогч нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан карт гаргах, карт хүлээн авах эрхтэй хуулийн этгээд байна.
 - 7.1.2. Хүсэлт гаргагч нь Клирингийн төвийн үйл ажиллагаанд Оролцогчоор бүртгүүлэхэд дараах баримт бичгийг Банкнд ирүүлнэ.
 - 7.1.2.1. Байгууллагын танилцуулга,
 - 7.1.2.2. Монголбанкнаас авсан зөвшөөрлийн хуулбар,
 - 7.1.2.3. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,
 - 7.1.2.4. Байгууллагын бүтэц зохион байгуулалтын зураг,
 - 7.1.2.5. Картын үйлчилгээний бизнес төлөвлөгөө болон үзүүлэх төлбөрийн үйлчилгээний танилцуулга, холбогдох баримт бичиг,
 - 7.1.2.6. Техник тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл,
 - 7.1.2.7. Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан,
 - 7.1.2.8. Бусад.
 - 7.1.3. Хүсэлт гаргагч нь энэхүү дүрмийн 7.1.2-т заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж ирүүлснээр Банк нь Оролцогчоор бүртгэх эсэхийг ажлын 30 хоногийн дотор шийдвэрлэж, шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногт мэдэгдэнэ.
 - 7.1.4. Хүсэлт гаргагч нь энэхүү дүрмийн шаардлагыг хангаж байвал Клирингийн төвийн гишүүнээр бүртгэхийг Банкны Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
- 7.2. Оролцогчоос түдгэлзүүлэх, хүчингүй болгох
 - 7.2.1. Оролцогч нь дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсныг эрх бүхий байгууллагаас зарласан, эсхүл татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан.
 - 7.2.2. Оролцогч нь хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь илэрсэн.
 - 7.2.3. Оролцогч нь Клирингийн төвтэй Төлбөрийн картын төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээг байгуулснаас хойш зургаа болон түүнээс дээш сарын хугацаагаар зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа эрхлээгүй.
- 7.3. Техник, программ хангамжийн шаардлага
 - 7.3.1. Карт гаргагч нь:
 - 7.3.1.1. Оролцогч нь Клирингийн төвтэй холбогдож чадахуйц Банкны үндсэн системтэй байна.

- 7.3.1.2. Оролцогч нь төлбөрийн картын гүйлгээг олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 стандартын дагуу дамжуулна.
 - 7.3.1.3. Оролцогч нь олон улсын PCI DSS-ийн шаардлагыг хангасан байна.
 - 7.3.1.4. Оролцогч нь олон улсын PCI PIN Security-ийн шаардлагыг хангасан байна.
 - 7.3.2. Карт хүлээн авагч нь:
 - 7.3.2.1. Оролцогч нь олон улсын PCI DSS-ийн шаардлагыг хангасан байна.
 - 7.3.2.2. Оролцогч нь олон улсын PCI PIN Security-ийн шаардлагыг хангасан байна.
 - 7.3.2.3. Оролцогч нь төлбөрийн картын гүйлгээг олон улсын санхүүгийн мэдээний ISO8583 стандартын дагуу дамжуулна.
 - 7.3.3. Оролцогч нь Банкны картын процессингийн төвтэй TCI болон TIC протоколоор холбогдоно.
 - 7.3.4. Оролцогч нь Банкны картын процессингийн төвтэй шифрлэсэн нууцлалын түлхүүр ашиглан холболт үүсгэнэ.
 - 7.3.5. Клирингийн төв нь шинэ технологи, үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор гүйлгээний бүтцэд өөрчлөлт оруулах бол үндсэн системд нэвтрүүлэхээс ажлын 45 хоногийн өмнө Оролцогчид мэдэгдэнэ.
 - 7.3.6. Шинэчилсэн гүйлгээний мессежний бүтцийг оролцогч талуудад хүргүүлж ажлын 30 хоногоос доошгүй хугацаанд хамтарсан туршилт, баталгаажуулалтыг хийнэ.
 - 7.3.7. Клирингийн төв нь үр дүнгийн хаалтын тооцооллын дүнг олон улсын санхүүгийн мэдээний ISO20022 стандартын дагуу Монголбанк руу дамжуулна.
 - 7.3.8. Оролцогч Монголбанкнаас баталсан төлбөрийн картын шаардлага болон олон улсын төлбөрийн системийн шаардлагыг хангасан байна.
- 7.4. Сүлжээний шаардлага
- 7.4.1. Оролцогч нь үндсэн болон нөөцийн төвтэй байна. Оролцогчийн үндсэн төвийг Банкны үндсэн төвтэй үндсэн болон нөөц шугамаар холбосон байна.
 - 7.4.2. Оролцогч нь Банкны дата төвтэй IPSEC VPN туннел сүлжээний холболт үүсгэн холбогдоно.
 - 7.4.3. Оролцогч нь өөрийн сүлжээний нууцлалыг хангаж ажиллана.
 - 7.4.4. Баазын аюулгүй байдлыг олон улсын CIS стандартын дагуу хангасан байна.
 - 7.4.5. Оролцогчийн Клирингийн төвтэй холбогдсон үндсэн болон нөөц сүлжээний холболт нь хоорондоо автоматаар шилждэг байна.
 - 7.4.6. Оролцогчийн сүлжээний төхөөрөмж нь Клирингийн төвийн сүлжээний төхөөрөмжтэй нийцэж ажиллах боломжтой байна.
 - 7.4.7. Оролцогч нь үндсэн болон нөөц төвийн сүлжээний орчныг тусгаарласан байдлаар зохион байгуулна.
- 7.5. Сүлжээний тасралтгүй байдал
- 7.5.1. Талууд сүлжээний тасралтгүй ажиллагаа, горимыг хангаж ажиллахад өөрийн зүгээс хамаарах аливаа бүх боломж нөхцөлийг хангаж ажиллахыг эрмэлзэнэ.
 - 7.5.2. Оролцогч нь үйл ажиллагааны тасралтгүй ажиллагааг хангах заавар гаргаж мөрдлөг болгон ажиллана.
 - 7.5.3. Оролцогчийн сүлжээний төлөвлөгөөт тасалдал нь сард 4 цаг, гэнэтийн саатал нь тухайн системийн нийт ажиллах цагийн 0.1 хувиас хэтрэхгүй байна.
 - 7.5.4. Талууд хоорондоо дамжуулж, солилцож буй нууц мэдээлэл (картын мэдээлэл, гүйлгээний мэдээлэл, тайлан мэдээ, файл солилцоо, бусад мэдээлэл)-ийн нууцлалыг чанд хадгалах талаар анхаарч ажиллах бөгөөд мэдээллийг кодлох,

нууц үг ашиглах, зөвхөн гэрээнд тусгасан хариуцсан ажилтнуудын холбогдох хаягийг ашиглах гэх мэт шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

7.5.5.Оролцогч нь өөрийн системд нэвтрэх эрхийн матрицийг бий болгож, түүнийг мөрдөж ажиллах бөгөөд энэ талаараа Банканд тухай бүр танилцуулна.

7.5.6.Төлөвлөгөөт зогсолт хийх болсон тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 2 хоногийн өмнө Төлөвлөгөөт зогсолт, гэнэтийн саатлын маягтыг бөглөж баталгаат цахим хаягаар хүргүүлнэ.

7.5.7.Системийн үйл ажиллагаа 2 минутаас дээш хугацаагаар, төлөвлөгөөт бусаар тасалдахыг гэнэтийн саатал гэнэ.

7.5.8.Талуудын сүлжээнд гэнэтийн саатал гарсан тохиолдолд нөгөө талдаа утсаар 10 минут, баталгаат цахим шуудангаар 20 минутын дотор Төлөвлөгөөт зогсолт, гэнэтийн саатлын маягтыг бөглөн хүргүүлнэ. Шаардлагатай арга хэмжээг авч хэвийн болсон тохиолдолд нөгөө талдаа утас болон цахим шуудангаар мэдэгдэнэ.

НАЙМ. БУСАД

8.1. Энэхүү дүрмийг Клирингийн төвийн болон Оролцогчийн ажиллагсад үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах ба хариуцсан нэгжийн удирдлага, хариуцсан захирал дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

8.2. Энэхүү дүрмээр тусгайлан зохицуулаагүй харилцааг холбогдох Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан болон ХасБанкны дотоод холбогдох журам, дүрэм, заавраар зохицуулна.

8.3. Удирдлага болгож буй эрх зүйн хэм хэмжээний өөрчлөлтөөс хамаарч энэхүү дүрмийн нэр томьёонд өөрчлөлт оруулах бол Оролцогчоос санал авахгүйгээр зохих өөрчлөлтийг оруулж Оролцогчид хүргүүлнэ.

8.4. Энэхүү дүрмийг шинэчлэн найруулах бол Оролцогчид мэдэгдэж санал авах бөгөөд харилцан тохиролцсоны үндсэн дээр шинэчлэн найруулж Оролцогчид хүргүүлнэ.

8.5. Энэхүү дүрмийн 8.3-т зааснаас бусад тохиолдолд энэхүү дүрэмд оруулах аливаа өөрчлөлтийг Оролцогчид ажлын 10 хоногт багтаан албан бичгээр хүргэж мэдэгдэнэ.

Гүйцэтгэх захирлын 2024 оны 1-р дугаар
тушаалын 2 дугаар хавсралт



ХАСБАНКНЫ КЛИРИНГИЙН ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

- 1.1. ХасБанк нь амжилттай дамжуулсан төлбөрийн картын гүйлгээний шимтгэлийг энэхүү нөхцөлд заасны дагуу тооцож суутгаж авна.
- 1.2. Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөлд өөрчлөлт орвол энэхүү нөхцөлд заасан шимтгэлийн хувь, хэмжээг уялдуулан өөрчилнө.
- 1.3. Оролцогч нь ХасБанкны клирингийн төвөөр гүйлгээний сэттлемент хийлгэхдээ гүйлгээ дамжуулсны шимтгэлийг доорх нөхцөлийн дагуу ХасБанкинд төлнө.

Үүнд:

№	Нэр төрөл	Агуулга	Шимтгэл	Төлбөрийн урсгал	Давтамж
1	Гүйлгээний сэттлемент	Бусад оролцогч болон дотоодын банк хооронд	20 төгрөг	Оролцогч -> ХасБанк	10,000 төгрөг болон түүнээс дээш дүнтэй гүйлгээ бүрээс
2			1 төгрөг	Оролцогч -> ХасБанк	10,000 төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ бүрээс

- 1.4. Оролцогчийн карт эзэмшигч нь ХасБанк эсхүл бусад оролцогчийн эквайрингийн сүлжээнд гүйлгээ хийсэн тохиолдолд амжилттай гүйлгээ тутамд доорх нөхцөлийн дагуу шимтгэл төлнө.

№	Нэр төрөл	Агуулга	Шимтгэл	Төлбөрийн урсгал	Давтамж	Шимтгэлийн тохиргоо	
						ACQ	ISS
1	Бэлэн мөнгө авах – ATM	Төгрөг	500 хүртэл төгрөг	Карт гаргагч -> Карт хүлээн авагч	Гүйлгээ бүр	Тийм	-
2	Мерчантын гүйлгээ	КҮБ (Гишүүн банк карт гаргагч бол)	-			Тийм	-
3		Интернэт мерчант	-			Тийм	-
4	Дансны үлдэгдэл шалгах	ATM-н дэлгэц	100 төгрөг			Тийм	-
5	Дансны товч хуулга	ATM	100 төгрөг			Тийм	-

6	Пин код солих	АТМ	-			Тийм	-
7	Шилжүүлэг хийх	АТМ картаас карт руу	300 хүртэл төгрөг			Тийм	-
8	Интернэт Пин код авах	АТМ	-			Тийм	-

1.5. Оролцогчийн карт эзэмшигч нь дотоодын банкны эквайрингийн сүлжээнд үйлчлүүлсэн эсхүл дотоодын банкны карт эзэмшигч оролцогчийн эквайрингийн сүлжээнд үйлчлүүлсэн бол доорх шимтгэлийг төлнө.

№	Нэр төрөл	Агуулга	Шимтгэл	Төлбөрийн урсгал	Давтамж
1	ПОС-ын худалдан авалтын гүйлгээ	Карт хүлээн авагч бол	0.3 хувь	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ -> Карт гаргагч банк	Үнийн дүнгээс
2			15 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	5000 төгрөг болон түүнээс дээш дүнтэй гүйлгээ бүрээс
3			2 төгрөг		1000 төгрөг-5000 төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ бүрээс
4			0.5 төгрөг		1000 төгрөгөөс доош дүнтэй гүйлгээ бүрээс
5		Карт гаргагч бол	0.3 хувь	Карт хүлээн авагч -> ҮЦГТ -> ХасБанк -> Оролцогч	Үнийн дүнгээс
6			15 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	5000 төгрөг болон түүнээс дээш дүнтэй гүйлгээ бүрээс
7			2 төгрөг		1000 төгрөг - 5000 төгрөг хүртэлх гүйлгээ бүрээс
8			0.5 төгрөг		1000 төгрөг буюу доош дүнтэй гүйлгээ бүрээс
9	Бэлэн мөнгө авах	Карт хүлээн авагч	50 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	Гүйлгээ бүрээс
10		АТМ	500 хүртэл төгрөг	Карт гаргагч -> ҮЦГТ -> Оролцогч	

11		Банкны салбар	Банкны нөхцөлийн дагуу		
12		Карт гаргагч бол	0 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	
13		АТМ	500 хүртэл төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ -> Карт хүлээн авагч	
14		Банкны салбар	Банкны нөхцөлийн дагуу		
15	АТМ болон Банкны салбарт дансны үлдэгдэл шалгах	Карт хүлээн авагч	10 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	
16			100 хүртэл төгрөг	Карт гаргагч -> ҮЦГТ -> ХасБанк -> Оролцогч	
17		Карт гаргагч	0 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	
18			100 хүртэл төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ -> Карт хүлээн авагч	
19	Цахим худалдан авалт	Карт хүлээн авагч	0.3%	Оролцогч -> ҮЦГТ-> ХасБанк -> Карт гаргагч	Үнийн дүнгээс
20			15 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	5000 төгрөг болон түүнээс дээш дүнтэй гүйлгээ бүрээс
21			2 төгрөг		5000 төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ бүрээс
22		Карт гаргагч	0.3%	Карт хүлээн авагч -> ҮЦГТ -> ХасБанк -> Оролцогч	Үнийн дүнгээс
23			15 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	5000 төгрөг болон түүнээс дээш дүнтэй гүйлгээ бүрээс
24			2 төгрөг		5000 төгрөг хүртэлх дүнтэй гүйлгээ бүрээс
25	Төрийн үйлчилгээний төлбөрийн гүйлгээ дамжуулах	Карт хүлээн авагч	0 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	Гүйлгээ бүрээс
26		Карт гаргагч	0 төгрөг		

27	АТМ – шилжүүлэг хийх	Карт хүлээн авагч	50 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	
28			300 хүртэл төгрөг	Карт гаргагч -> ҮЦГТ -> ХасБанк -> Оролцогч	
29		Карт гаргагч	0 төгрөг	-	
30			300 хүртэл төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ -> Карт хүлээн авагч банк	
31	АТМ – орлогын гүйлгээ хийх	Карт хүлээн авагч	100 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	
32		Карт гаргагч	0 төгрөг	-	

1.6. ВИЗА интернэйшнл байгууллагын брэндийн картын гүйлгээг хүлээж авах болон гаргахад доорх төрлийн шимтгэлийг төлнө.

1.6.1. Олон улсын банкны карт эзэмшигч нь оролцогчийн эквайрингийн сүлжээнд гүйлгээ хийх эсхүл Оролцогчийн карт эзэмшигч Олон улсын банкны эквайрингийн сүлжээнд гүйлгээ хийсэн бол ХасБанкаар дамжуулан доорх шимтгэлийг төлнө/хүлээн авна.

№	Нэр төрөл	Агуулга	Шимтгэл	Төлбөрийн урсгал	Давтамж	Ашиглалт
1	Бэлэн мөнгө	Карт гаргагч – АТМ	Гүйлгээ бүрээс 1.5 америк доллар + гүйлгээний үнийн дүнгийн 0.5 хувь	Оролцогч -> ХасБанк	Гүйлгээ бүрээс	Тийм
2		Карт хүлээн авагч	Гүйлгээний үнийн дүнгийн 0.26 хувь	VISA -> ХасБанк -> Оролцогч		Тийм
3	Худалдан авалтын гүйлгээ	Карт гаргагч	1 хувь	Оролцогч -> ХасБанк		Тийм
4		Карт хүлээн авагч	2 хувь	Оролцогч -> ХасБанк -> VISA		Тийм

1.6.2. Энэхүү дүрмийн 1.6.1-т заасан хүснэгтийн хоёр дахь мөрөнд заасан карт хүлээн авагчийн үйлчилгээний төлбөрийг сар бүрийн 5-ны өдрийн дотор багтаан нэхэмжлэхийг үндэслэн Оролцогчид шилжүүлнэ.

1.7. Юнион Пэй Интернэйшнл байгууллагын брэндийн картыг хүлээн авах болон гаргахад доорх төрлийн шимтгэлийг төлнө.

1.7.1. Олон улсын банкны карт эзэмшигч нь Оролцогчийн эквайрингийн сүлжээнд гүйлгээ хийх болон Оролцогчийн карт эзэмшигч нь Олон улсын эквайрингийн сүлжээнд гүйлгээ хийсэн бол доорх шимтгэлийг ХасБанкаар дамжуулан Юнион Пэй Интернэйшнл болон ҮЦГТ-д төлнө/хүлээн авна.

№	Нэр төрөл	Агуулга	Шимтгэл	Төлбөрийн урсгал	Давтамж	Ашиглалт
1	АТМ төхөөрөмжийн үйлчилгээ	Үлдэгдэл шалгах гүйлгээ	5 төгрөг	Оролцогч -> ХасБанк -> ҮЦГТ	Гүйлгээ бүрээс	Тийм
2		Бэлэн мөнгө авах	100 төгрөг			
3	ПОС-худалдан авалтын гүйлгээ	Карт хүлээн авагч	0.05 хувь			
4		Карт хүлээн авагч	1.2 хувь	Оролцогч -> ХасБанк -> Юнион Пэй Интернэйшнл		

1.7.2. Оролцогчийн Юнион Пэй Интернэйшнл карт эзэмшигч нь Олон улсын эквайрингийн сүлжээнд бэлэн мөнгө болон худалдан авалтын гүйлгээ хийсэн болон Олон улсын карт эзэмшигч нь Оролцогчийн эквайрингийн сүлжээнд гүйлгээ хийсэн тохиолдолд ХасБанкны клирингийн төвийн үйлчилгээний нөхцөлийн 1.3-т заасан төлбөрийг ХасБанкинд төлнө.

1.7.3. Олон улсын банкны карт эзэмшигч нь Оролцогчийн эквайрингийн сүлжээнд бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол ХасБанк доорх шимтгэлийг Оролцогчид төлнө.

№	Нэр төрөл	Агуулга	Шимтгэл	Төлбөрийн урсгал	Давтамж	Ашиглалт
1	АТМ төхөөрөмжийн үйлчилгээ	Үлдэгдэл шалгах	0.1 америк доллар	ХасБанк -> Оролцогч	Гүйлгээ бүрээс	Тийм
2		Бэлэн мөнгө авах	0.6 америк доллар			

1.7.4. Энэхүү дүрмийн 1.7.3-т заасан үйлчилгээний төлбөрийг Оролцогчоос сар бүрийн 5-ны өдрийн дотор багтаан ирүүлсэн нэхэмжлэхэд үндэслэн шилжүүлнэ.


1.8. Буцаалтын гүйлгээний шимтгэлийг буцааж буй дүнгээс тооцож залруулгын гүйлгээг хийнэ.

1.9. Энэхүү дүрмийн нөхцөл өөрчлөгдөх тохиолдолд Оролцогчид хуанлийн 7 хоногоос багагүй хоногийн өмнө мэдэгдэнэ.




ОЛОН УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ БОЛОН ОРОЛЦОГЧИЙН ТӨЛБӨРИЙН КАРТЫН ГҮЙЛГЭЭНИЙ ЗУРАГЛАЛ

Схем 1. Оролцогч хоорондын гүйлгээг дараах байдлаар дамжуулна.




Схем 2. Оролцогч ҮЦГТ хоорондын гүйлгээг дамжуулна.



Схем 3. Оролцогч VISA хоорондын гүйлгээг дамжуулна.



Схем 4. Оролцогч UPI хоорондын гүйлгээг дамжуулна.





Гүйцэтгэх захирлын 2024 оны 1-р дугаар
тушаалын 4 дүгээр хавсралт

ГҮЙЛГЭЭ БОЛОВСРУУЛАХ, ҮР ДҮНГИЙН ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ АРГАЧЛАЛ

- 1.1. Клирингийн төв нь Оролцогч талуудын төлбөрийн картын гүйлгээг өөрийн системээр дамжуулан гүйцэтгэх ба үр дүнгийн тооцооллыг Монголбанкны “Банксүлжээ” системээр дамжуулна.
- 1.2. Үр дүнгийн тооцооллыг заасан хуваарийн дагуу боловсруулж дамжуулна.

№	Гүйлгээ хийсэн гараг	Үр дүнгийн тооцоолол боловсруулах гараг	Дамжуулах цаг
1	Даваа	Мягмар	11:00 – 14:00
2	Мягмар	Лхагва	11:00 – 14:00
3	Лхагва	Пүрэв	11:00 – 14:00
4	Пүрэв	Баасан	11:00 – 14:00
5	Баасан	Даваа	11:00 – 14:00
6	Бямба		
7	Ням		
8	Нийтээр амрах баярын өдөр	Дараагийн ажлын өдөр	11:00 – 14:00

- 1.3. Клирингийн төв нь Оролцогч талуудын хоорондох нийт өглөг, авлагыг тооцох, бүртгэх, хоорондын тооцоог барагдуулах, нийлэх үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 1.3.1. Оролцогч хооронд,
 - 1.3.2. Оролцогч болон дотоодын банк хооронд,
 - 1.3.3. Оролцогч болон олон улсын банк хооронд.
- 1.4. Клирингийн төв нь картаар хийгдсэн карт гаргагч талын “зөвшөөрсөн” гүйлгээний Үр дүнгийн тооцооллыг хийхдээ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-146 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөлийг дагаж мөрдөнө.
- 1.5. “Зөвшөөрсөн” хариу өгсөн гүйлгээний дүнтэй холбогдох төлбөрийг карт гаргасан тал бүрэн хариуцна.
- 1.6. Оролцогч талуудын хоорондын тооцоонд хамрагдах аливаа гүйлгээ, холбогдох шимтгэл, талуудын хоорондох нийт өглөг, авлагыг үнэн зөв тооцон бүртгэж хоорондын тооцоог барагдуулна. Ийнхүү тооцох, бүртгэх, барагдуулахад шаардлагатай тохиргоог оролцогч талууд систем дээрээ үнэн зөв тохируулж бэлтгэсэн байна.
- 1.7. Оролцогч талуудын хооронд тооцоог барагдуулах үед валют хөрвүүлэх бол Оролцогчид харилцан тохиролцсон ханшийг баримталж гүйлгээг хийнэ.
- 1.8. Картаар хийгдэж буй зөвшөөрөл хүссэн гүйлгээний хариуд тухайн картыг гаргасан банк эсхүл Оролцогч зөвшөөрсөн хариу өгсөн бол тухайн гүйлгээтэй холбоотой төлбөрийг карт гаргасан тал хариуцна.
- 1.9. Клирингийн төв нь дараах үүрэгтэй:
 - 1.9.1. Оролцогч талуудын хоорондын тооцоог барагдуулахад нягтлан бодох бүртгэлийн нийтлэг үндсэн зарчмыг баримтална.
 - 1.9.2. Оролцогч хооронд болон дотоодын бусад банкны эквайрингийн сүлжээнд хийсэн гүйлгээ, өглөг, авлага, тооцоололтой холбоотой асуудлыг Клирингийн

- төвөөр дамжуулан шийдвэрлэх бөгөөд үүссэн асуудлыг ҮЦГТ-тэй хамтран шийдвэрлэнэ.
- 1.9.3. Клирингийн төв нь Оролцогч хоорондын эквайрингийн сүлжээнд хийгдсэн гүйлгээний хаалтын гүйлгээний тайланг тухайн ажлын өдөрт багтаан Оролцогчид илгээнэ.
 - 1.9.4. Клирингийн төв нь Оролцогч тус бүрийн хаалтын тайланг Оролцогчийн нэрийн өмнөөс Монголбанк дахь түр дансаар дамжуулан гүйцэтгэнэ.
 - 1.9.5. Клирингийн төв нь Оролцогчийн нэрийн өмнөөс хийсэн хаалтын тайланг үндэслэн талуудын хооронд үүссэн төлбөр тооцоог Монголбанк дээр байршиж буй Оролцогч тус бүрийн дансаар дамжуулан гүйцэтгэнэ.
- 1.10. Оролцогч нь дараах үүрэгтэй:
- 1.10.1. Тухайн өдрийн өмнөх өдрийн Оролцогчийн карт эзэмшигч бусад Оролцогчийн эквайрингийн сүлжээнд хийсэн гүйлгээ болон бусад оролцогчийн карт эзэмшигчийн Оролцогчийн эквайрингийн сүлжээнд хийсэн гүйлгээний мэдээллийг тухайн өдрийн 14:30 цагаас өмнө боловсруулсан байна.
 - 1.10.2. Бусад Оролцогчоос илгээсэн тайланг системээс хүлээн авч үнэн эсэхийг тулгана.
 - 1.10.3. Оролцогч нь энэхүү аргачлалын 1.9.5-д заасан тооцоо үнэн зөв эсэхийг тайлантай тулгана.
 - 1.10.4. Оролцогч нь Клирингийн төвийн анхны шаардлагаар бусад Оролцогчид төлөх аливаа өглөгийг төлж барагдуулна.
 - 1.10.5. Оролцогчийн карт эзэмшигчийн бусад Оролцогчийн эквайрингийн сүлжээнд хийсэн “зөвшөөрсөн” төлөвтэй гүйлгээний дүнтэй холбоотой төлбөрийг хариуцна.
 - 1.10.6. Оролцогч талуудын систем дээр бүртгэгдэж буй гүйлгээ, холбогдох шимтгэл, талууд хоорондын нийт өглөг, нийт авлага, тооцоог тогтмол хянах үүрэгтэй. Хяналтын явцад зөрүү илэрсэн буюу тодруулах асуудал, маргаан үүссэн бол өөрсдийн үндэслэл, тооцооллыг ажлын 3 өдрийн дотор нөгөө талд мэдэгдэж асуудлыг хамтран шийдвэрлэнэ. Асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар протокол үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.
- 1.11. Оролцогчийн нэрийн өмнөөс Клирингийн төвийн барагдуулсан Оролцогч болон дотоодын банк хоорондын тооцоог үндэслэн талуудын хооронд үүсэх төлбөр тооцоог харилцах дансаар дамжуулан гүйцэтгэнэ.
- 1.12. Оролцогчийн карт эзэмшигч олон улсын банкны эквайрингийн сүлжээнд эсхүл олон улсын банкны карт эзэмшигч Оролцогчийн эквайрингийн сүлжээнд гүйлгээ хийсний мэдээллийг үндэслэн Клирингийн төв нь тухайн ажлын өдөрт багтаан Outgoing файлуудыг Edit package/TW interchange web-EDI програмаар дамжуулан Оролцогчийн нэрийн өмнөөс VISA International /UnionPay International байгууллагуудад илгээнэ.
- 1.13. Клирингийн VISA International /UnionPay International байгууллагаас ирүүлсэн Incoming файлуудыг Edit package/TW interchange web-EDI программаас авч боловсруулна.
- 1.14. Оролцогч нь Клирингийн төвийн Илгээсэн, Хүлээн авсан гүйлгээний мэдээлэл бүхий файл тайлангийн агуулгын үнэн зөв эсэхийг шалгана.
- 1.15. Оролцогч нь VISA International /UnionPay International байгууллагад төлөх аливаа өглөгийг Клирингийн төвийн анхны шаардлагаар төлж барагдуулна.
- 1.16. Оролцогч болон бусад банк, байгууллагын хооронд үүссэн аливаа авлага, өглөгийг талуудын хоорондын төлбөр тооцооны дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

- 1.17. Клирингийн төв нь сар бүр төлөх VISA International /UnionPay International байгууллагын Оролцогчид ногдох төлбөрийг “ХасБанкны клирингийн төвийн үйлчилгээнийн Оролцогчид ногдох төлбөрийг Клирингийн төвөөс уг дүнг нэхэмжлэн авна.
- 1.18. VISA International /UnionPay International байгууллагын Оролцогчоос нэхэмжилж буй болон VISA International /UnionPay International байгууллагын Оролцогчид төлж буй өдөр тутмын гүйлгээнээс бусад шимтгэл, хураамжийн төлбөр тооцоог хоорондын тооцооны дансаар дамжуулан гүйцэтгэнэ.